

**АЙМГИЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ  
“АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ САН”-ГИЙН ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Архидан согтуурахтай тэмцэх сан/ цаашид Сан гэнэ/-гийн зорилго нь Ховд аймгийн хөгжлийн стратеги /2015-2025 он/-ийн “Иргэдийн амгалан тайван амьдрах нийгмийн орчныг бүрдүүлэх стратеги” /5.3/ зорилтын хүрээнд ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 154 дүгээр тогтоолоор батлагдсан “Архигүй тамхигүй Ховдчууд” хөтөлбөрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд оршино.

1.2. Сангийн үйл ажиллагааг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл / цаашид ГХУСА33/-өөс байгуулагдсан салбар зөвлөл хариуцан зохицуулна. Салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын орлогч тэргүүлнэ. Зөвлөлийн ажлын албаны үүргийг Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс хариуцна.

1.3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн гишүүдийн олонхийн оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

1.4. Зөвлөл хэлэлцсэн асуудлаа олонхийн саналаар шийдвэрлэж, ГХУСА33Зөвлөлийн шийдвэр гаргуулна.

1.5. Сангийн зөвлөл үйл ажиллагаагаа жил бүр аймгийн ИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд тайлагнана.

**Хоёр. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт**

Сангийн хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ

2.1. “Архигүй тамхигүй Ховдчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгод нийцүүлэн орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулах хөрөнгө

2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан хөрөнгөнөөс энэ хөтөлбөрийн үйл ажиллагаанд зориулан тусгайлан хуваарилсан хөрөнгө

2.3. Архидан согтуурахтай тэмцэх ажлыг дэмжиж иргэд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүнчлэн олон улсын болон гадаадын байгууллага, иргэдээс үзүүлсэн хандив, тусламжийн хөрөнгө;

2.4. Хууль тогтоомжид үл харшлах бусад орлого.

Сангийн зөвлөл “Архигүй тамхигүй Ховдчууд” хөтөлбөрийн зорилго зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг жил бүр төлөвлөж зохих журмын дагуу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн гарсан саналыг тусган ИТХ-д оруулна.

### **Гурав. Сангийн хөрөнгийн зарцуулалт**

Сангийн хөрөнгийг сангийн зөвлөлийн саналыг харгалзан ГХУСАЗЗөвлөлийн даргын шийдвэрээр дараахь зориулалтаар зарцуулна:

3.1. архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар гарсан хууль тогтоомжийн талаар хэлэлцүүлэг, мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах

3.2. архи, тамхины хор хөнөөл, хүний эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгэмд учрах хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх болон архи, тамхины зохистой, соёлтой хэрэглээг олон нийтэд төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа

3.3. Сум, баг бүрээр архинд донтох өвчтэй хүмүүсийн судалгаа гаргах, архи, тамхинаас гарах хүсэлтэй иргэдэд туслан, нөлөөлөх ажил хариуцан хийх эрүүл мэндийн байгууллага болон сайн дурын бүлэг, төрийн бус байгууллагуудад гэрээний үндсэн дээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх

3.4. архидан согтуурах явдалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй оролцсон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах.

3.5 Архигүй тамхигүй Ховдчууд” хөтөлбөрийн зорилго зорилтод нийцсэн бусад үйл ажиллагаа явуулах

### **Дөрөв. Сангийн зөвлөлийн эрх хэмжээ**

4.1. Сангийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэлэлцэн батлах

4.2. Сангийн хөрөнгө зарцуулах санал гаргах

4.3. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл хөтөлбөр шалгаруулах

4.4. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээ, төсөл хөтөлбөрийн явцад хяналт тавьж, үр дүнг шалгах, холбогдох мэдээ тайлан гаргуулж хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх

**Тав. Сангийн ажлын албаны үйл ажиллагаа**

5.1 Сангийн ажлын алба хариуцсан хэлтэс зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулж, зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулна.

5.2. Сангийн хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах ажлыг зохицуулж, сангийн хөрөнгө бусад үйл ажиллагаатай холбогдох санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх

oooOooo